

*ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Орос судлалын сектороос 2010 оны 05 дугаар сарын 14-нд зарим яам, агентлаг, эрдэм шинжилгээ, судалгааны болон төрийн байгууллагуудын дунд “Монгол-Оросын худалдаанд тулгамдаж буй асуудлууд тэдгээрийг шийдвэрлэх арга зам” сэдэвт семинар зохион байгуулсан юм. Уг семинарын үндсэн илтгэлийг энэхүү дугаарт нийтлэв.*

## **МОНГОЛ-ОРОСЫН ХУДАЛДААНЫ АСУУДАЛ**

*А.Даваасүрэн\**  
*Н.Отгонсайхан\*\**

### **I. Монгол Улсаас ОХУ-тай хийж буй худалдааны өнөөгийн байдал**

Монгол, Оросын хувьд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа нь олон жилийн түүхэн уламжлалтай билээ. 1990 оныг хүртэл Монгол Улсын нийт гадаад худалдаанд Орос улс дийлэнх буюу 80 орчим хувийг эзэлж ирсэн.

1990 оны эхэн үеэс дэлхийн социалист систем задран унаж, түүнд багтаж байсан Төв болон Зүүн Европын улс орнууд болон ЗХУ, БНМАУ зэрэг улсууд нийгэм, эдийн засгийн бүх салбарт өөрчлөлт, шинэчлэлтийг хийх замаар төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас татгалзаж, зах зээлийн эдийн засаг руу шилжих шилжилтийг эхлүүлсэн. Энэхүү өөрчлөлт, шинэчлэлтийг хийснээр өмнө нь ах дүүгийн гэх харилцаатай байсан манай хоёр орны хувьд зах зээлийн шинэ нөхцөлд бие биеийнхээ эрх ашгийг хүндэтгэн, эрх тэгш, харилцан ашигтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх цоо шинэ хуудас нээгдэх болсон гэж үзэж болно. Харамсалтай нь өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад хоёр орны хоорондох худалдаа, эдийн засгийн харилцаа нь хөгжлийн нилээд хүнд үеийг туулж Монгол Улсын дэлхийн улс орнуудтай хийж буй гадаад худалдааны нийт эргэлтэнд ОХУ-ын эзлэх хувийн жин эрс буурч 1997 оноос хойш 19-23 орчим хувь болсныг график 1-ээс харж болно.


\* А.Даваасүрэн - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), профессор

\*\* Н.Отгонсайхан - докторант



*Эх уулав: Монгол Улсын ҮСХорооны жил тутмын статистикийн эмхтгэл (1990-2009); ред. Ю.Аюуш “БНМАУ-ын гадаад худалдааны хөгжилт”, 1981*

1990 оныг хүртэл Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтэнд ЗХУ-тай хийх худалдааны хувь хэмжээ нилээд тогтвортой байсан бол 1990 оноос огцом буурч 1995 онд 60 гаруй хувиар буурч, улмаар 2004 онд 19,2 хувь болж хамгийн доод түвшинд хүрч, 2008 оноос бага зэрэг өсөж 23,0 хувь болсон ч 2009 онд дахин буурсан. Харин тус оронтой хийх гадаад худалдааны нийт эргэлт үнийн дүнгээр тогтвортой өсөж 2008 онд 1.3 тэрбумд долларт хүрч анх удаа 1990 оны үеийн 1,23 тэрбум ам.долларын түвшингээс давсан. Хоёр орны гадаад худалдааны эргэлийг ийнхүү өсгөхөд ОХУ-ын экспорт чухал байр суурьтай байж манай улсын гадаад худалдааны алдагдлыг ихээхэн нэмэгдүүлж, худалдааны нөхцлийг бууруулсан нь тийм ч таатай бус үзүүлэлт юм.<sup>1</sup> 2009 онд манай улсын гадаад худалдааны нийт эргэлт тэрбум гаруй, ОХУ-тай хийсэн худалдааны эргэлт хагас тэрбум орчим ам.доллараар огцом буурсныг график 2-оос харж болно.




*Эх сурвалж: Монгол Улсын ҮСХорооны жил тутмын статистикийн эмхтгэл (2000-2009)*

Хоёр орны хоорондын худалдааны бууралтад олон хүчин зүйл нөлөөлсөн гэж үздэг. Тухайлбал, хоёр улсын хооронд өмнө нь тогтсон аж ахуйн болон үйлдвэрлэлийн хэлхээ холбоо, бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн нийлүүлэлтийн сүлжээ задарсан; хоёр орон хоёулаа бараа, бүтээгдэхүүний хомсдолд орж зах зээлээ нэн тэргүүнд шаардлагатай бараа бүтээгдэхүүнээр хангах зорилготой дэлхийн бусад орнуудтай гадаад худалдааг хийх болсон; гадаад хатуу валютын нөөцийн хомсдол зэрэг болно.

Энэхүү хүнд хэцүү үед хоёр улсын төрийн тэргүүний өмнө олон улсын болон бүс нутгийн санхүүгийн байгууллагуудад гишүүнээр элсэж тэдгээрээс тусламж авах, хатуу валютыг зээлэх, төлбөрийн чадвартай худалдааны өөр шинэ түншийг хайх, тэдэнтэй холбоо тогтоох шаардлага тулгарсан.

Ийнхүү 1990 оноос манай улсын гадаад худалдааны бүтцэд ихээхэн өөрчлөлт орж өнөөдөр 100 гаруй оронтой гадаад худалдаа хийж байгаа бөгөөд ОХУ-ын манай гадаад худалдаанд эзлэх хувь хэмжээг бусад гол түнш орнууд болох Хятад, Япон, Солонгос, АНУ, Европын Холбооны улсууд, Канадын<sup>2</sup> хувь хэмжээтэй харьцуулж диаграмм 1-д<sup>3</sup> харуулъя.




Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2008, 2009

Хэдийгээр манай хоёр орон шилжилтийн хүнд хэцүү үеийг даван туулж, хоёр улсын худалдаа, эдийн засгийн уламжлалт харилцааг сэргээх талаар ихээхэн идэвхи санаачлага гарган Засгийн газар хоорондын хэлэлцээрүүд хийж эрх зүйн зохих баримт бичгүүдэд гарын үсэг зурсан ч хоёр орны хоорондын худалдаанд дорвитой өөрчлөлт алга байна.

Монгол Улсын ОХУ-тай хийх гадаад худалдааны тэнцлийн хувьд зөвхөн 1991 онд 3,1 сая ам.долларын ашигтай гарч байсан бол түүнээс хойшхи хугацаанд тогтмол алдагдалтай байж, улмаар энэ нь жил тутам өсөн нэмэгдэж 2008 онд хамгийн их буюу 1156,0 сая ам.долларын алдагдалд хүрсэнийг график 3-аас харж болно. Харин ОХУ-аас Монгол

Улстай хийж буй гадаад худалдааны тэнцэл байнгын ашигтай байдаг. ОХУ-тай хийж буй гадаад худалдаанд хэтэрхий тэгш бус байдал үүссэн нь манай улсын гадаад худалдааны алдагдал өндөр гарах,<sup>4</sup> худалдааны нөхцөл муу байх зэрэгт ихээхэн нөлөөлж байна.



*Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл*

Монгол Улс, ОХУ-ын хоорондын худалдааны балансын зөрүү нь ОХУ-д мөрдөгдөж байгаа импортын өндөр татвараас зохих хэмжээгээр хамааралтайг Монгол-Оросын ЗГХК-ын 1999 оны ҮII хуралдааны Протоколд тэмдэглэж, хоёр орны хоорондын худалдааг либералчлах хамтарсан ажлын хэсгийг байгуулахаар шийдвэрлэсний дагуу Монгол, Оросын худалдааг либералчлах ажлын хэсэг нилээдгүй хэлэлцээ, зөвлөлдөөн хийжээ.

Хэлэлцээний хүрээнд, ОХУ-аас импортолж байгаа нефть бүтээгдэхүүн, эрчим хүч, Монголын экспортын бараанд үйлчилж байгаа болон ОХУ-ын нутгаар дамжин өнгөрч буй ачааны тээврийн тариф, ОХУ-ын хилээр зорчигч болон бараа, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхэд гаалийн журмыг хөнгөвчлөх асуудлаар хэлэлцээ хийх саналуудыг өгч байсан. Манай улс Оросын талтай хэлэлцээ хийх шаардлагатай гэж үзсэн экспортын 21 нэрийн барааны жагсаалт, тухайлбал, ОХУ-ын талд импортын татвараа мах, махан бүтээгдэхүүнд 6.3-3.1 хувь, арьс, шир болон үслэг, нэхий эдлэлд 5-3 хувь, хивсэнд 3 хувь, оёмол, сүлжмэл, ноолууран эдлэлд 5-3 хувь болгон бууруулах жонш, зэсийн баяжмал, молибденийн хүдэр, баяжмалыг татваргүй болгох санал тавьсан байна. Үүний үр дүнд 2001 онд ОХУ-ын импортын татварыг мах, махан бүтээгдэхүүн, эрдсийн бүтээгдэхүүнд 25 хувиар бууруулсан.

Гэсэн хэдий ч 2003 оноос алдагдал огцом өссөн дүр зураг график 3-аас харагдаж байна.

Манай улсын экспортын бараа маш хязгаарлагдмал, түүхий эд давамгайлсан өрөөсгөл бүтэцтэй. Нийт экспортод эрдэс бүтээгдэхүүний

эзлэх хувийн жин өндөр<sup>5</sup> байгаа нь бусад орны түүхий эдийн хавсрага болох магадлал өндөр улс орны тоонд нэгэнт багтжээ.

Монгол Улсын нийт экспортод ОХУ 3-3.4 хувийг<sup>6</sup> эзэлж байгаа бөгөөд одоогоор хайлуур жонш,<sup>7</sup> махны экспортын хувьд ОХУ-аас улсаас хэт хамааралтай бөгөөд ОХУ руу хийж буй нийт экспортын 50 хувийг<sup>8</sup> /2009 онд жоншны нийт экспорт буурсан/ зөвхөн жонш эзэлдэг. Харин нэмүү өртөг шингэсэн эцсийн хэрэглээний уламжлалт ноос, ноолуур, эсгий бүтээгдэхүүн болон хивсний экспорт өчүүхэн бага хувийг эзэлж байна.

Урьд нь манай улс зөвхөн үхэр, адууны хөлдүү махыг хоёр, гуравхан аж ахуйн нэгж ОХУ руу экспортолдог байсан бол 2010 оны 4 сарын 15-наас Монгол Улсын 9 аж ахуйн нэгжээс нэмүү өртөг шингэсэн эцсийн бэлэн бүтээгдэхүүн болох махан бүтээгдэхүүн импортлох шийдвэрийг ОХУ-ын мал эмнэлэг, хорио цээрийн албанаас гаргасан нь маш чухал ач холбогдолтой болж байна.

Монгол Улсын нийт импортод нефть бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээ өндөр байдаг.

Монгол Улсын нийт импортод ОХУ хамгийн их буюу 36-38 хувийг<sup>9</sup> эзэлдэг бөгөөд уламжлал ёсоор Монгол Улс ОХУ-аас бүхий л төрлийн өргөн хэрэглээний бараа, хүнсний бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмжийг импортоор авч байна. Бензин, дизелийн түлшний хувьд ОХУ-аас хэт их хамааралтай. Тухайлбал, стратегийн бүтээгдэхүүнүүд болох бензин, дизелийн түлшний импортын 90 гаруй /2007-94.1 хувь, 2008-94.7 хувь, 2009-94.4 хувь/, гурилын импортын 70 гаруй хувийг /2007-78.6 хувь, 2008-73.4 хувь, 2009-87.5 хувь/ зөвхөн ОХУ-аас авч байна. Манай улсад нийлүүлж байгаа ОХУ-ын экспортын 60 гаруй хувь<sup>10</sup> нь бензин, дизелийн түлш байдаг бол 25 гаруй хувь нь хөдөө аж ахуйн болон хүнсний бүтээгдэхүүн /гурил 3 хувь/ эзлэж байна.

Олон улсын жишгээр<sup>11</sup> стратегийн бүтээгдэхүүний хэрэглээнд импортоор авч буй хувь /нефть 35 хувь, гурил 30 хувь/ өндөр байх, тодорхой бүтээгдэхүүний 20-оос дээш хувийг зөвхөн нэг улсаас импортолдог бол уг орон тэр орноос эдийн засгийн хараат болсон гэж үздэг ажээ.

Иймээс Монгол Улсын хөгжлийн тулгуур баримт бичгүүдийн үзэл баримтлалтай уялдуулан мал аж ахуйн болон эрдэс түүхий эдийн эцсийн боловсруулалт хийх дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх оновчтой хувилбар, арга замыг судалгаа шинжилгээний үндсэн дээр боловсруулах нь туйлын чухал байна. Манай улсын ДНБ-нд шинжлэх ухаан, судалгааны ажлын зардлын эзлэх жин 0.3 орчим хувь байгаа нь олон улсын жишгээс /2 хувь/ нилээд доогуур үзүүлэлт юм.

## **II. Монгол Улсаас ОХУ-тай хийж буй худалдаанд гарч буй хүндрэл**

Монгол Улсаас ОХУ-тай хийж буй гадаад худалдаанд хэтэрхий тэгш бус байдал үүссэн нэг гол шалтгаан нь тус улсын тарифийн болон тарифийн бус саад бэрхшээл гэж хэлж болох юм.

ОХУ нь гадаадын компаниудыг тус улсын өргөн хэрэглээний барааны зах зээл дээр хялбархан нэвтрүүлэхээс нилээд болгоомжилж байдаг.

Тус улсын гадаад худалдааны бодлогын хууль эрх зүйн эх сурвалж нь ерөнхийлөгч, засгийн газар болон тэдгээрийг гүйцэтгэх байгууллагуудаас гаргасан албан ёсны хууль, тогтоол, тушаалууд болж байна. Эдгээрээс гол эрх зүйн актуудыг дурьдвал:

- Гадаад худалдааны үйл ажиллагаан дахь төрийн зохицуулалтын тухай хууль, 2003 он
- Гаалийн тарифийн тухай хууль, 1993 он
- Гаалийн тарифийн хөнгөлөлт үзүүлэх тухай, Гаалийн улсын хорооны тушаал, 2003 он

“Гадаад худалдааны үйл ажиллагаан дахь төрийн зохицуулалтын тухай хууль”-аар тарифийн болон тарифийн бус арга хэрэгслийн ямар төрлийг ямар тохиолдолд хэрхэн ашиглаж гадаад худалдааг зохицуулах талаар зааж өгсөн.

“Гаалийн тарифийн тухай хууль”-аар гаалийн тарифийн шатлал, татварын төрөл, гаалийн үнэлгээ болон татварын хөнгөлөлтийг заасан.

Гаалийн тарифийн тухай хууль болон Гаалийн тарифийн хөнгөлөлт үзүүлэх тухай, Гаалийн улсын хорооны тушаалын дагуу ОХУ импортын бараанд ногдуулж буй гаалийн тарифийн шатлалыг дараах байдлаар тогтоохоор заасан. Үүнд:

- ОХУ-аас худалдааны нэн таатай нөхцөл олгож буй орнуудаас гарал үүсэлтэй импортын бараанд гаалийн татварын үндсэн тарифыг ногдуулдаг. /нэн таатай нөхцөл олгох 135 орны жагсаалтыг гаргасан/
- ОХУ-аас нэн таатай нөхцөл олгоогүй орнуудаас гарал үүсэлтэй импортын бараанд гаалийн татварын үндсэн тарифыг 2 дахин нэмж ногдуулдаг.
- ОХУ-аас Хөнгөлөлтийн ерөнхий системийн дагуу тусгай хөнгөлөлт олгож байгаа хөгжиж байгаа орнуудаас гарал үүсэлтэй импортын бараанд гаалийн татварын үндсэн тарифын 75 хувийг ногдуулдаг. /104 орны болон хөнгөлөлтөд хамрагдах барааны жагсаалтыг гаргасан/
- ОХУ-аас Хөнгөлөлтийн ерөнхий системийн дагуу тусгай хөнгөлөлт олгож байгаа нэн буурай хөгжилтэй орнуудаас гарал үүсэлтэй импортын бараанд гаалийн татвар

ногдуулдаггүй. /51 орны болон хөнгөлөлтөд хамрагдах барааны жагсаалтыг гаргасан/

- ТУХН-ийн болон ЕАЭЗХН-ийн орнуудаас гарал үүсэлтэй импортын бараанд гаалийн татвар ногдуулдаггүй.
- ОХУ, Беларусь, Казакстан улсууд гаалийн холбоо байгуулснаар хоорондоо гаалийн татвараа тэглэж, гуравдагч орнуудтай хийх гадаад худалдаандаа гаалийн нэгдсэн бодлого явуулахаар болж байгаа бөгөөд үүнтэй холбоотой “ОХУ-ын гаалийн зохицуулалтын тухай хууль”-ийг баталж, 2010 оны 7 сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчлэх гэж байна.

ОХУ-ын Засгийн газар гаалийн тариф болон гаалийн нутаг дэвсгэрийн хүрээнд тус орны худалдааны бодлогыг хэрэгжүүлэхэд тарифын хөнгөлөлтийг зарим төрлийн бараанд тогтоох эрхтэй байдаг.

ОХУ импортын гаалийн татварыг тогтоохдоо тухайн барааны боловсруулалтын түвшинг харгалзан тогтоодог. Тухайлбал, голчлон түүхий эдэд 0-5, хагас боловсруулсан бүтээгдэхүүнд 5-15, бэлэн бүтээгдэхүүнд 15-аас дээш байдаг.

Монгол Улс нэн тааламжтай нөхцөл болон хөнгөлөлтийн ерөнхий системийн дагуу тусгай хөнгөлөлт олгох хөгжиж буй орнуудын жагсаалтад багтаж байгаа болно.

**Монгол Улсын гол нэрийн экспортын барааг ОХУ-д нийлүүлэхэд мөрдөгдөж байгаа гаалийн татварын хэмжээ Хүснэгт 1.**

№	Барааны код	Барааны нэр	Хөнгөлөлтэй тариф буюу үндсэн тарифын 75%	Үндсэн тариф
1	201	Үхрийн шинэ буюу хөргөөсөн мах	11.25	15
2	202	Үхрийн хөлдүү мах	11.25	15
3	203	Гахайн мах	11.25	15
4	204	Хонь, ямааны мах	11.25	15
5	205	Адууны мах	11.25	15
6	206	Малын дйвар бүтээгдэхүүн	11.25	15
7	302	Төрөл бүрийн загас	7.5	7.5
8	1101-1103	Төрөл бүрийн гурил	7.5	7.5
9	1214	Малын тэжээл, шар манжин, бусад тэжээлийн ургамал	3.75	3.75
10	15,021,505	Малын өөх, тос, ланолин	11.25	15
11	1601, 1602	Махан бүтээгдэхүүн	11.25-15	15-20
12	19	Гурилан бүтээгдэхүүн	11.25	15

13	2208	Архи, спиртлэг ундаа	1л-ээс 1.5 евро	1л-ээс 2 евро
14	2302, 2309	Үр тарианы хаягдал, мал амьтны тэжээл	3.75	5
15	25	Шохой, цемент, тоосго, гипс, эрдэс чулуу	3.75	5
16	2529	Жонш, лейцит, нефелин	3.75	5
17	2603	Зэсийн хүдэр ба баяжмал	3.75	5
18	2613	Молибдений хүдэр ба баяжмал	3.75	5
19	3501	Элдэмцэр /казеин /	3.75	5
20	4104-4111	Боловсруулсан арьс, шир	3.75	5
21	4203	Савхи, илгэн хувцас	15	20
22	4302	Элдсэн арьс	3.75	5
23	4303	Үслэг эдлэлээр хийсэн хувцас /нэхий хувцас/	3.75	5
24	25	Хивс	22.5	30
25	61	Сүлжмэл хувцас, эдлэл	22.5	30
26	62	Оёмол хувцас	22.5	30
27	6509.92	Үслэг малгай	22.5	30

Түүнчлэн ОХУ-ын НӨАТ-ын татвар өндөр буюу 18 хувь байдаг нь манай экспортын барааны өрсөлдөх чадварыг бууруулж байна. Үүн дээр ОХУ-ын дотоодын төмөр замаар тээвэрлэх дотоодын нэгдсэн тариф 10,9 хувь нэмэгдэж тооцогддог. ОХУ-ын төмөр замын тариф нь гаалийн тарифтай адил бараа, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамаарч өсөх хэлбэрээр тогтоогддог. Тухайлбал, зэс болон молибдений баяжмалыг дотоодын төмөр замаар тээвэрлэхэд энэхүү тарифийг дунджаар 15,7 хувиар өсгөж тооцдог, хэрэв зэсийн гулдмай болон цэвэр молибденийг тээвэрлэхэд 10,9 хувийг 7 хувиар бууруулж тооцдог байна.

Хэдийгээр манай улс махан бүтээгдэхүүн экспортлох боломжтой болсон ч зөвхөн гаалийн болон НӨАТ-аас үнэ 30 гаруй хувь, түүнчлэн манай экспортын гол нэрийн нэмүү өртөг шингэсэн бараа болох савхи, нэхий болон оёмол сүлжмэл бүтээгдэхүүний үнэ 45 орчим хувиар нэмэгдэхээр байна.

Түүнчлэн манай улсын гарал үүсэлтэй зарим нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн тус улсын нутаг дэвсгэрээр тээвэрлэхэд тээврийн маш өндөр тарифийг тогтоосоор байна. ОХУ-аас ногдуулж байгаа эдгээр гаалийн тариф болон тарифийн бус хязгаарлалт, тээврийн өндөр зардлаас болж манай улсын зарим төрлийн бэлэн бараа бүтээгдэхүүний үнэ 60-80 хувиар нэмэгдэж оросын хэрэглэгчдийн гар дээр очиж байна. Энэ байдал нь манай экспортын бараа, бүтээгдэхүүний үнийг өсгөх болж, тэдгээрийн өрсөлдөж чадварыг бууруулж, тэдгээрийн нэр төрлийг олшруулахад саад учруулж байна.



ОХУ-ыг ДХБ-д элсэхтэй холбогдуулан 2005 онд манай 2 улс Женевт 8 дахь удаагийн хэлцэл хийж, албан ёсны тэмдэглэлд гарын үсэг зурсан.<sup>12</sup> ОХУ-ын талаас 600 нэрийн гаруй барааны гаалийн тарифийн саналыг ирүүлсэн бөгөөд манай улс 100 гаруй барааны гаалийн татвар дээр анхаарал хандуулсан. ОХУ-ын анхны санал нь тухайн үед мөрдөж байсан тарифаас 50, үүний дотор ХАА-н гаралтай барааны тариф нь 100 хувь өндөр байсныг удаа дараагийн хэлэлцээ хийсний үндсэн дээр нийт барааны дундаж тариф 13 хувь, үүнээс ХАА-н бараа 12 хувь байхаар, эдгээр тарифийн түвшинд хүрэх шилжилтийн хугацааг 2.2 жил байхаар тохиролцжээ. Түүнчлэн дараагийн шилжилтийн үед импортын дундаж тарифийг 7.5, үүнээс аж үйлдвэрийн бараанд 5 хувь, ХАА-н барааны татварыг өөрчлөхгүй байх, газрын тос, түлш эрчим хүчний бүтээгдэхүүн болон хар, өнгөт металл зэрэг чухал түүхий эдээс бусад экспортын барааны гаалийн татварыг ДХБ-д элссэнээс хойш аажмаар бууруулж 4 жилийн хугацаанд тэглэхээр үүрэг амлалт авчээ.

Тэгэхээр ОХУ нь ДХБ-д элссэн тохиолдолд дээрх татварын түвшин нилээд буурч манай улсын талд ашигтай хувилбар гарч ирэх ч бусад орнуудтай тус улсын зах зээл дээр хүчтэй өрсөлдөх нь дамжиггүй.

ОХУ-тай манай улс худалдаа хийхэд өндөр гаалийн тарифаас гадна тарифийн бус хориг саадууд нилээд гардаг. Ялангуяа манай экспортын гол нэрийн бараа болох махны хувьд мал эмнэлгийн өндөр шаардлага, квот, тарифийн квот, төлбөр тооцооны гэх мэт хүндрэлүүд байнга гарч байна.

ОХУ-ын махны холбооны мэдээгээр импортын махны квотыг өнөөдрийн түвшинд бариад, дотоодын махны үйлдвэрлэлийн өсөлт энэ хэвээрээ байвал 2010-2011 онд зах зээл дээр махны илүүдэл болно. Иймээс дотоодын үйлдвэрлэлийн өсөлтийн прогноз дээр үндэслэн квот тогтоох шаардлагатай гэдгийг зөвлөжээ. 2009 оны 1 сарын 1-нээс тогтоосон квотоос дээш гарсан гахайн махны тарифийг 75, шувууны махны тарифийг 95 хувиар өсгөж, харин үхрийн хөргөсөн болон хөлдөөсөн махны тарифийг 30 хувиар бууруулсан бөгөөд 2009 онд махны импорт 500 мян.тн-оор буурчээ.

Манай улс жилд 60 орчим тн мах экспортод гаргах квоттой ч мал эмнэлгийн өндөр шаардлага, төлбөр цаг хугацаандаа хийгдэхгүйгээс эргэлтийн хөрөнгийн дутагдалд орох, үнийн чөлөөт өрсөлдөөн байхгүй зэргээс зарим үед дээрх квотод хүргэж махаа экспортолж чадахгүй байна. ОХУ-ын тал заасан квотдоо хүргэж нийлүүлж чадахгүй байгаа нь танай талын асуудал гэдэг.

Түүнчлэн манай жижиг бизнес эрхлэгчид сард нэг удаа 35 кг-аас илүүгүй ачаа хилээр гаргах эрхтэй байдгаас хил дээр бараагаа хураалгах, хил гаалийн ажилтнуудад хахууль өгөх, эд материал болоод сэтгэл санааны дарамтад орох зэрэг хүндрэл учирч байна. Мөн тээврийн

зардал өндөр, манай зах зээлийн багтаамжаас шалтгаалан ОХУ-аас суудлын вагон буюу зориулалтын бус тээврийн хэрэгслээр хүнсний бүтээгдэхүүн зөөж байгаа нь хадгалалтын горим алдагдаж<sup>13</sup> эрүүл ахуйн шаардлага хангахгүй бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэгдэж хүнсний аюулгүй байдлыг алдагдуулахад нөлөөлж байна.<sup>14</sup>

Эцэст нь эдгээр хүндрэл бэрхшээлийг хоёр улсын ард түмэн, татвар төлөгчид буюу хэрэглэгчид нуруун дээрээ үүрч байгааг тэмдэглэх нь зүйтэй.

### III. Дүгнэлт, санал

Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтэнд ОХУ-ын эзлэх хувийн жин 1990-ээд оноос эрс буурч сүүлийн жилүүдэд 20 орчим хувийг эзэлж байна. Түүнчлэн Монгол Улсаас ОХУ-тай хийж буй гадаад худалдаанд хэтэрхий тэгш бус байдал бий болсноос гадаад худалдааны алдагдал өсөх, худалдааны нөхцөл муудах нэг гол нөхцөл болжээ.

Хоёр орны хооронд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны талаар олон гэрээ, хэлэлцээр хийгдсэн боловч гадаад худалдаанд дорвитой өөрчлөлт авч ирсэнгүй. Ирэх жилүүдэд Монгол Улсын ОХУ руу экспортлох махан бүтээгдэхүүний бодит хэмжээ, үр ашгийг хүлээх л үлдлээ.

Монгол Улсаас ОХУ-тай хийж буй нийт экспортын 50 хувийг жонш, нийт импортын 60 гаруй хувийг бензин, дизелийн түлш эзэлж байгаа нь нэг талаас хоёр орны экспорт, импортын бүтэц хязгаарлагдмал, нөгөө талаас дээрх бүтээгдэхүүнүүдийн хувьд манай улс тус улсаас хараат болох боломжтойг харуулж байна гэж дүгнэж болох юм.

Манай улсын ОХУ-тай хийх экспорт бага байгаа нь тус улсын импортын гаалийн татвар болон тээврийн зардал өндөр, квот тогтоодог, чанар эрүүл ахуй, мал эмнэлгийн өндөр шаардлага тавьдаг, төлбөр тооцоог цаг хугацаандаа хийдэггүй, гаалийн бүрдүүлэлтийн хугацаа урт, хүнд сурталтай байдаг зэрэгтэй ихээхэн холбоотой. Гэвч хоёр орны гадаад худалдаанд тэгш бус байдал бий болсныг зөвхөн ОХУ-ын тарифийн болон тарифийн бус саад бэрхшээлтэй холбон үзэж болохгүй. Манай улс өөрийн экспортын нөөц боломжиндоо тулгуурлан үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, шинэ техник технологийг нэвтрүүлэх, барааны чанар, аюулгүй байдлыг олон улсын хэмжээнд баталгаажуулах, хүлээн зөвшөөрүүлэх асуудал чухал байна.

Дээрх асуудлууд дээр үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна.

Манай улс өөрийн улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангахуйц, олон талт хамтын ажиллагааны хүрээнд гадаад худалдааны бодлогоо боловсронгуй болгож, төрийн зохицуулалтыг зах зээлийн механизмтай оновчтой уялдуулах замаар хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайлбал, импортыг орлох болон экспортын чиглэлтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг ДХБ-ын хэлэлцээрүүдийн хүрээнд

бодлогоор дэмжиж дорвитой арга хэмжээ авах, хүнсний болон нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний зах зээлийн төрийн зохицуулалтыг гаалийн ялгавартай татварын бодлогоор оновчтой, дэс дараалалтайгаар зохицуулах гэх мэт.

Түүхий эд, эрдэс бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх оновчтой хувилбар, арга замыг судалгаа шинжилгээний үндсэн дээр боловсруулах, эдийн засаг, нийгэм, экологийн нөлөөллийг нь тооцох асуудал туйлын чухал байна.

Монгол Улсаас ОХУ-руу экспортлох боломжтой бараа бүтээгдэхүүний нөөц боломжийг тодорхойлж, тус улсаас эдгээр бараанд хэрэглэж буй тарифийн болон тарифийн бус хориг саадын сөрөг нөлөөллийг нарийвчлан судлаж, үр дүнтэй бол тэдгээрийг хөнгөлөлттэй нөхцлөөр нийлүүлэхэд шаардлагатай гэрээ хэлэлцээрийг хийх, мах, ноос, ноолуур боловсруулах хамтарсан үйлдвэрийг “Алтанбулаг”, “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсүүдэд байгуулж хамтран ажиллах, үр ашиггүй эсвэл хүндрэлтэй бол бусад улсын зах зээлд гаргах боломж, нөхцлийг хайх хэрэгтэй.

ОХУ-аас импортолж байгаа цахилгаан, эрчим хүчний тарифыг бууруулах, хоёр орны хооронд тодорхой нэр төрлийн бараагаар чөлөөт худалдааны тогтолцоо бий болгох асуудлыг судлах, Монголын мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд тавьж буй мал эмнэлгийн шаардлагыг зөөллөх тал дээр хамтран ажиллах, ОХУ-ын нутгаар тээвэрлэж байгаа манай экспорт, импортын болон транзит барааны төмөр замын тээврийн тарифыг бууруулах талаар яриа хэлэлцээгээ цаашид үргэлжүүлэх.

Манай бизнес эрхлэгчид тодорхой бараагаар төрөлжиж, хоорондоо уялдаа холбоотой ажиллах, ОХУ-тай хийх экспортын барааны өрөөсгөл бүтцийг сайжруулах, аялал жуулчлал зэрэг үйлчилгээний экспортыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

ОХУ-ын ДХБ-д нэгдэн орох талаар хийж буй хэлэлцээ, түүнчлэн ОХУ болон Монгол Улс ОХУ-ыг ДХБ-д элсэн орохтой холбогдсон хоёр талын хэлэлцээрийг эргэн харах нь зүйтэй.

### ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. 2007 онд экспорт 58.5 , импорт 745 сая ам.долл, 2008 онд тус тус 86.3, импорт 1242.3 сая ам.долл, 2009 онд тус тус 64.2, 769.6 сая ам.долл байсан.
2. Эдгээр орнууд гадаад худалдааны нийт эргэлтийн 90 гаруй хувийг эзэлдэг.
3. ҮСХ-ны дарга, Сангийн сайд, Гаалийн Ерөнхий газрын даргын 2009 оны 2 дугаар сарын 17-ны хамтарсан тушаалаар батлагдсан “Гадаад худалдааны барааны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу 2005 оноос хойшхи мэдээллийг нэгтгэсэн байна. Иймээс шинэ аргачлалын дагуу өөрчлөлт орсон мэдээллийг ашиглав.
4. 2008 онд Монгол улсын гадаад худалдааны алдагдал 710сая ам. доллар байсан.
5. 2007 онд 65.4%, 2008 онд 60.3%, 2009 онд 66.8%
6. 2007 онд 3%, 2008 онд 3.4%, 2009 онд 3.4% , харин Хятад улс холбогдох онуудад 72.5%, 64.5%, 73.1% байна.
7. Монгол улсын хайлуур жоншны экспортын дийлэнх хувийг ОХУ дангаараа эзэлж байна. /2007 онд 62%, 2008 онд 76.3%, 2009 онд 66.2%/.
8. 2007-47.6%, 2008-52.3%, 2009-30.6%
9. 2007 онд 36.1%, 2008 онд 38.3%, 2009 онд 36.1%, харин Хятад улс холбогдох онуудад 27.6%, 27.7%, 25.0% байна
10. 2007 онд 64.4%, 2008 онд 63.2%, 2009 онд 60.6%,
11. Эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой шалгуур үзүүлэлтүүдийг НҮБ, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, ОХУ-ын стратеги судалгааны институт зэрэг олон улсын байгууллагуудаас тогтоожээ.
12. ОХУ-ыг ДХБ-д элсэхтэй холбогдон тарифийн талаар үүрэг амлалт авах явцад манай улс оролцож зарим нэг барааны хувьд INR /initial negotiation rights/ буюу цаашид ОХУ-ыг тухайн барааны тарифийн дээд түвшинг/bound tariff/ өсгөх шаардлагатай болсон үед манай улстай хэлцэл хийх ба бидэнд бусад барааны хувьд тарифийг бууруулах боломж бүрдэж болох давуу талтай юм.
13. Москвагаас 5 хоног халуун вагонд тээвэрлэн ирж байна.
14. Ийм маягаар бизнес эрхлэгчдийг Монголын хил дээр мэргэжлийн хяналтхан саатуулагдаг ч хахууль өгч, авалцаад л оруулдаг. Их хэмжээтэй гэрээ байгуулж чаддаггүйгээс шаардлагатай баримт бичгүүд байдаггүй. Контейнерээр зөөхөд хэтэрхий бага, хүргэлт удаан

**Ашигласан материал**

1. Аюуш.Ю. болон бусад. БНМАУ-ын гадаад худалдааны хөгжилт. УБ., 1981
2. О таможенном тарифе. Федеральный закон от 21 мая 1993 г.
3. Монгол Улсын статистикийн эмхэтгэл
4. О предоставлении тарифных преференций . Приказ от 25 декабря 2003 г.
5. Об основах государственного регулирования внешнеторговой деятельности, Федеральный закон от 8 декабря 2003 г.
6. Отгонсайхан Н. Гадаад худалдааны бодлого ба эдийн засгийн аюулгүй байдлын асуудалд. ХҮДС-ийн багш нарын эрдэм шинжилгээний бичиг. УБ., 2008. х. 186-193
7. Таможенный кодекс РФ (в ред. От 20 августа 2004 г.)
8. Otgonsaikhan N. Foreign trade policy issues in Mongolia. “The 4<sup>th</sup> Conference of Northeast Asian Professor’s Association(NAPA)” Greater Tumen Initiative and Local Economic Cooperation in Northeast Asia. 2010, p.261-272,

<http://www.mongoliatrade.mn/>

<http://www.kapital-rus.ru/articles/article/20808>

<http://www.rosbalt.ru/economics/>

[www.minfin.ru](http://www.minfin.ru)

[www.cbr.ru](http://www.cbr.ru)

<http://ru.wikipedia.org/wiki>

<http://www.rusimpex.ru/index1.htm?varurl=Content/Economics/>

<http://www.esp-izdat.ru/?article=1080>

[http://www.vch.ru/cgi-bin/guide.cgi?table\\_code=15&action=show&id=861](http://www.vch.ru/cgi-bin/guide.cgi?table_code=15&action=show&id=861)

[www.rian.ru/finans/20090112/158976876.html](http://www.rian.ru/finans/20090112/158976876.html)

<http://www.investorov.net/invest/81.htm>

<http://www.bn.ru/news/2009/06/30/44448.html>